



**БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН
БИЕЙН ТАМИР, СПОРТ ХОРООНЫ
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 02 сарын 13 өдөр

Дугаар A/11

Улаанбаатар хот

Г Өмч хамгаалах байнгын зөвлөлийн Г
ажиллах журам, бүрэлдэхүүнийг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1,11.2 дахь хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3, Төрийн өмчийн хорооны 2018 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 86 дугаар тогтоолыг үндэслэн тус тус ТУШААХ нь:

1.Байгууллагын "Өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажиллах журам"-ыг Нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2.Өмч хамгаалах байнгын

Зөвлөлийн дарга:

Нарийн бичиг:

Гишүүд:

-Нярав

-Хүний нөөц, бичиг хэрэг

-Спортын хэлтсийн дарга


-Тогтоол шийдвэрийн биелэлт, хяналт шинжилгээ үнэлгээний асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн

-Спортын сургалт-дасгалжуулалтын бодлогын хэрэгжилтийн асуудал хариуцсан мэргэжилтэн


3.Төрийн өмч хөрөнгийг ариг гамтай ашиглах байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн журмыг мөрдүүлэн, өмч хөрөнгөнд хяналт тавьж ажиллахыг өмч хамгаалах зөвлөлийн дарга (О.Түмэнжаргал)-д үүрэг болгосугай.

4.Өмч хамгаалах зөвлөлтэй холбогдуулан гаргасан 2022 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн байгууллагын даргын А/31 дүгээр тушаалыг хүчингүй болгосугай.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Д.ОТГОНСҮРЭН



ӨМЧ ХАМГААЛАХ БАЙНГЫН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг журам

- 1.1.Энэхүү нийтлэг журмын зорилго нь төрийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах зөвлөлийн зохион байгуулалт, үйл ажиллагаанд баримтлах зарчим, эрх, үүргийг тодорхойлоход оршино.
- 1.2.Өмч хамгаалах зөвлөл нь орон тооны бус байнгын үйл ажиллагаатай байна.
- 1.3.Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагаанд хамтын шийдвэр гаргах, ил тод, шуурхай, хариуцлагатай байх зарчмыг баримтална.
- 1.4.Өмч хамгаалах зөвлөлд Төрийн орон нутгийн өмчийн тухай хууль, Иргэний хууль, Татварын тухай багц хууль, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Засгийн газар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, холбогдох байгууллагаас баталсан тогтоол, шийдвэр, дүрэм журмыг мөрдлөг болгон ажиллана.
- 1.5.Энэхүү журмыг төрийн өмчийн хуулийн этгээд өмч хамгаалах зөвлөл үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана.

Хоёр.Зөвлөлийн үйл ажиллагааны зохион байгуулалт

- 2.1.Төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлага нь өмч хамгаалах зөвлөлийг 5-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй байгуулна.
- 2.2.Төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлага зөвлөлийн бүрэлдэхүүний чиг үүргийг ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн болон үр дүнгийн гэрээнд нь тусгаж, ажиллах нөхцөл боломжоор хангана.
- 2.3.Өмч хамгаалах зөвлөл нь ажлын төлөвлөгөөг боловсруулж, жил бүр 01 дүгээр сарын 15-ны дотор багтаан хуулийн этгээдийн удирдлагаар батлуулж ажиллана.
- 2.4.Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Зөвлөлийн дарга хуралдааныг даргална. Даргын эзгүйд түүний даалгаснаар аль нэг гишүүн хуралдааныг даргална.
- 2.5.Өмч хамгаалах зөвлөлийн хуралдаан ээлжит болон ээлжит бус хэлбэртэй байна.
- 2.6.Өмч хамгаалах зөвлөлийн ээлжит хуралдааныг хагас бүтэн жил тутамд зохион байгуулна. Зөвлөлийн хуралдаанд олонх оролцсоноороо хүчин төгөлдөр болно.
- 2.7.Өмч хамгаалах зөвлөлийн ээлжит хагас бүтэн жил тутамд зохион байгуулна. Зөвлөлийн хуралдаанд олонх оролцсоноороо хүчин төгөлдөр болно. Асуудлыг хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.
- 2.8.Ээлжит бус хуралдааныг зөвлөлийн даргын товлосноор буюу гишүүдийн гуравны нэг болон удирдлагын санал болгосноор зарлан хуралдана.
- 2.9.Өмч хамгаалах зөвлөлийн гишүүн асуудлыг танилцуулна. Тухайн асуудлыг боловсруулан албан хаагч нэмэлт мэдээлэл, тайлбар өгөх зорилгоор хуралдаанд байлцана.
- 2.10.Хуралдаанд хууль тогтоомжид нийцсэн, зохих судалгаа, тооцоо, нотлох баримтад үндэслэсэн, санхүүгийн болон хөрөнгийн холбогдох бусад мэдээлэл бүхий материалыг эд хөрөнгийн зохицуулалтын холбогдох журамд нийцүүлэн бэлтгэсэн асуудлыг хэлэлцэнэ.
- 2.11.Өмч хамгаалах зөвлөлийн шийдвэрийн тусгасан хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл хөтөлнө.
- 2.12.Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэлийг ажлын 3 өдөрт багтаан бичиж хуралдаан

даргалагч, гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна.

2.13. Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэлд дараах зүйлийг тусгана:

2.13.1. Хурал болсон огноо, эхэлсэн, засварласан дууссан цаг минут,

2.13.2. Хурал болсон газар,

2.13.3. Хурлын ирц, хуралд оролцоогүй гишүүдийн нэр, шалтгаан,

2.13.4. Хэлэлцсэн асуудал, түүнийг танилцуулсан болон байлцсан этгээдийн нэр, албан тушаал,

2.13.5. Хэлэлцсэн асуудалтай холбогдуулж тавьсан асуулт, хариулт, санал, дүгнэлт, танилцуулга, тайлбар, хурлаас гарсан шийдвэр,

2.14. Өмч хамгаалах зөвлөл санал боловсруулах, шийдвэр хэрэгжүүлэхдээ эрх бүхий байгууллагаас баталсан төрийн өмчийн бүртгэлийн болон захиргааны статистикийн мэдээллийн маягт, үндсэн хөрөнгө хүлээн авах, шилжүүлэх, ашиглалтаас хасах, устгах баримт болон зохих бусад материалыг ашиглана.

2.15. Өмч хамгаалах зөвлөлийн дарга жилийн ажлын төлөвлөгөөний хэрэгжилт, зөвлөлийн гишүүдийн ирц, чиг үүргийн биелэлтийг жилд 2-оос доошгүй удаа гүйцэтгэх удирдлагадаа танилцуулна.

2.16. Өмч хамгаалах зөвлөлийн тухайн жилд гүйцэтгэсэн ажил, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтын байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал зэргийг тусгасан ажлын тайланг дараа жилийн ажлын төлөвлөгөөний хамт жил бүрийн 01 дүгээр сарын 15-ны өдөрт багтаан удирдлагад танилцуулан баталгаажуулж, төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээнд хавсаргана.

Гурав. Өмч хамгаалах зөвлөлийн эрх, үүрэг

3.1. Өмч хамгаалах зөвлөл нь төрийн өмчийн аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт хамгаалалт сайжруулах, ашиглалтад хяналт тавих, түүний үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авч ажиллана.

3.2. Өмч хамгаалах зөвлөл нь өмчийн харилцааны асуудлаар авч хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын төсвийг боловсруулж төсөвт тусгуулах арга хэмжээ авсан байна.

3.3. Өмч хамгаалах зөвлөл нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу хуулийн этгээдийн эд хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, шилжүүлэх, актлах, данснаас хасах зэрэг эд хөрөнгийн зохицуулалт, төрийн өмчийн үр ашгийг дээшлүүлэх асуудлыг судалж, дараах байдлаар зөвлөмж дүгнэлт гаргана,

3.3.1. Хуулийн этгээдийн чиг үүрэг, үндэслэл, зах зээлийн үнийн харьцуулсан судалгаа, хөрөнгийн тоо хэмжээ, үнийн дээд хязгаар, техникийн болон бусад шаардлагын талаар зөвлөмж,

3.3.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалт, зээл, хандив, тусламж, бэлэглэл, өр төлбөрт тооцон олж авсан хөрөнгө, төслийн шугамаар бий болсон эд хөрөнгийн чанар байдлыг харгалзан элэгдэл, хорогдлыг нь тооцон ашиглах хугацааг тогтоож дүгнэлт,

3.3.3. Хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй эд хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх бол хөрөнгө хүлээн авах хуулийн этгээдтэй урьдчилан зөвшилцөж дүгнэлт,

3.3.4. Хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй эд хөрөнгийг худалдах бол хөрөнгийг худалдах доод үнийн санал бүхий дүгнэлт,

3.3.5. Хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй эд хөрөнгийг акталж данснаас хасах бол үндэслэл, хөрөнгийг ерөнхий болон техникийн байдлыг нэг бүрээр газар дээр нь шалгаж дүгнэлт,

3.3.6. Эд хөрөнгийн дотоодын тооллогын дүнгээр дутагдсан, маргаантай, илүүдэлтэй ашиглалтгүй хөрөнгийн шалтгааныг тогтоож дүгнэлт,

3.3.7. Удирдлагад хуулиар олгосон бүрэн эрхээ хэрэгжүүлэх, тухайн асуудлыг

- шийдвэрлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор зөвлөмж өгөх,
- 3.4.Өмч хамгаалах зөвлөл нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчит эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ыг удирдлага болгоно.
- 3.5.Төрийн өмчит хуулийн этгээдийн эргэлтийн хөрөнгөнд хамаарах эд хөрөнгийг шилжүүлэх, худалдах, акталж данснаас хасах асуудлыг өмч хамгаалах зөвлөл судлан дүгнэлт гаргах бөгөөд хуулийн этгээдийн удирдлагын тушаалаар шийдвэрлэнэ. Өмч хамгаалах зөвлөл шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг гүйцэтгэнэ.
- 3.6.Төрийн өмчит хуулийн этгээлийн удирдлага нь өмч хамгаалах зөвлөлийн зөвлөмж, дүгнэлтийг үндэслэн үндсэн хөрөнгө олж авах, бүртгэх шилжүүлэх, худалдах, акталж данснаас хасах санал хүргүүлэхээр шийдвэрлэсэн тохиолдолд зөвлөл нь дор дурдсан шаардлагыг хангаж төрийн өмчийн бодлого зохицуулалтын асуудал эрхэлсэн эрх бүхий байгууллагад хүсэлтийг хүргүүлэх ажлыг зохион байгуулна:
- 3.6.1.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж дүрэм журмын хүрээнд санал ирүүлэх,
- 3.6.2.Хуулийн этгээдийн эрх барих эсхүл харьяа дээд байгууллагад уламжилж санал авсан байх,
- 3.6.3.Эрх бүхий байгууллагаас баталсан эд хөрөнгийг зохицуулалтын журамд заасан материалын бүрдлийг бүрэн хангаж энэхүү журмын 2,3 дугаар хавсралтад заасан загварын дагуу хөрөнгийн жагсаалтыг үнэн зөв, баримт бичгийн стандартын шаардлага хангаж ирүүлэх,
- 3.6.4."Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагын мэдээлэлжүүлэх систем"-д шийдвэрийн хэрэгжилтийг тухай бүр оруулсан эсэх, системийн бүрэн дүүрэн, аюулгүй байдалд хяналт тавих
- 3.7.Төрийн өмчит хуулийн этгээд нь үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах саналаа жил бүрийн 4,9 дүгээр сард багтаан ирүүлж байна.
- 3.8.Өмч хамгаалах зөвлөл нь эрх бүхий байгууллагын эд хөрөнгийн зохицуулалтын шийдвэрийг гүйцэтгэх удирдлагын тушаалаар комисс томилон хэрэгжүүлэх, биелэлтийг заасан хугацаанд албан бичгээр хүргүүлэх үүрэг хүлээнэ.
- 3.9.Өмч хамгаалах зөвлөл нь төрийн өмчийн харилцааг зохицуулах, хууль тогтоомж, холбогдох бусад хууль, дүрэм журмыг мөрдөж ажиллахыг тухайн хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага, холбогдох ажилтнаас шаардах, тайлбар гаргуулах эрхтэй.
- 3.10.Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээсээр эзэмшүүлэх, ашиглуулах, түрээсийн орлогыг төвлөрүүлэлт, зарцуулалт, түрээсийн хөрөнгийн ашиглалт, чанар байдалд хяналт тавьж ажиллана.
- 3.11.Хөрөнгө олж авах зардлын төлөвлөлт, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулахад хяналт тавьж ажиллана.
- 3.12.Төрийн өмчийг үрэгдүүлэх, чанар байдлыг доройтуулах, эдвэж гэмтэхээс урьдчилан сэргийлэх талаар зохиох арга хэмжээ авах, зөрчил гаргасан этгээдтэй хариуцлага тооцох асуудлыг холбогдох хууль, эрх зүйн хүрээнд шийдвэрлэнэ.

Дөрөв.Бусад

- 4.1.Өмч хамгаалах зөвлөл нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, зөрчлийн тухай хууль болон өмчийн харилцаатай холбоотой бусад хууль тогтоомж, эрх зүйн актад заасан хариуцлага хүлээнэ.
- 4.2.Төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлага нь хуулийн өмч хамгаалах зөвлөлийн ажлын үр дүнгээс хамааруулан холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн урамшуулал олгоно.